



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/2/СТА-ОНӨААН**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: [orkhon@audit.gov.mn](mailto:orkhon@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: [www.dalaivanaudit.mn](http://www.dalaivanaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар



## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. Менежментийн захидал .....	16

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.03.15 № 89  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

"ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА  
ЗАХИАЛАГЧИЙН АЛБА"  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Ц.БАЯРЖАРГАЛ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>72,615,085.61</u></b>	<b><u>106,929,008.69</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	22,895,341.83	98,374,407.98
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	22,700,819.44	98,374,407.98
31213	Арилжааны банк дахь харилцах	22,700,819.44	98,374,407.98
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>25,747,784.49</b>	<b>20,360.71</b>
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	2,149,135.49	20,360.71
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>14,877,960.00</b>	<b>1,200,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	14,877,960.00	1,200,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>9,093,999.29</b>	<b>7,334,240.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,865,350.00	1,941,050.00
35110	Тусгай зориулалттай материал	1,865,350.00	1,941,050.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>7,228,649.29</b>	<b>5,393,190.00</b>
35410	Бичиг хэргийн материал	366,062.00	890,000.00
35420	Аж ахуйн материал	3,223,500.00	2,771,500.00
35470	Бусад хангамжийн материал	3,639,087.29	1,731,690.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>899,633,180.49</u></b>	<b><u>906,572,620.49</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	899,633,180.49	906,572,620.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>89,088,567.49</b>	<b>95,128,007.49</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,231,943.77	17,231,943.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	354,981.00	4,483,769.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,710,000.00	49,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	21,426,667.00	18,129,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,541,252.72	71,079,208.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	45,213,747.05	33,919,595.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,196,142.73	40,008,242.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	27,595,376.68	26,508,523.68
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>810,544,613.00</b>	<b>811,444,613.00</b>
39301	Програм хангамж	7,035,000.00	7,935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,541,250.00	3,541,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	807,050,863.00	807,050,863.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>972,248,266.10</u></b>	<b><u>1,013,501,629.18</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,697,884.63</u></b>	<b><u>7,074,098.90</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,697,884.63	7,074,098.90
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,697,884.63</b>	<b>7,074,098.90</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,697,884.63	7,074,098.90
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	1,697,884.63	7,074,098.90
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>970,550,381.64</u></b>	<b><u>1,006,427,530.28</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	970,550,381.64	1,006,427,530.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	830,830,863.00	830,830,863.00
51101	Өмч: - төрийн	830,830,863.00	830,830,863.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	138,764,055.87	174,641,204.51
51210	Өмнөх үеийн үр дүн	120,654,903.27	140,213,557.51
51220	Тайлант үеийн үр дүн	18,109,152.60	34,427,647.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	955,462.77	955,462.77
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>972,248,266.27</u></b>	<b><u>1,013,501,629.18</u></b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>426,048,796.41</b>	<b>462,663,407.33</b>
120002	Хүүгийн орлого	600,693.24	126,112.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<b>425,448,103.17</b>	<b>462,537,294.55</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	414,762,103.17	462,537,294.55
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>407,939,643.64</b>	<b>424,786,707.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>405,237,349.64</b>	<b>424,786,707.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>197,226,871.98</b>	<b>246,906,928.00</b>
210101	Үндсэн цалин	124,807,905.00	153,917,328.00
210102	Нэмэгдэл	15,147,200.00	21,094,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,465,645.00	16,608,000.00
210104	Урамшуулал	30,732,876.98	31,006,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,073,245.00	24,280,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,207,559.44</b>	<b>30,700,375.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,597,596.12	20,987,088.88
210202	Тэтгэмжийн даатгал	1,577,814.98	1,975,255.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,971,968.72	2,469,069.28
210204	Ажилгүйдлийн даатгал	394,453.74	493,813.86
210205	Эрүүл мэндийн даатгал	3,944,537.44	4,775,147.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,180,166.29</b>	<b>22,145,163.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,503,740.44	1,784,272.00
210302	Түлш, халаалт	3,412,425.85	3,484,498.00
210304	Байрны түрээс	12,300,000.00	16,876,393.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,536,297.96</b>	<b>30,758,187.53</b>
210401	Бичиг хэрэг	6,785,280.76	10,224,411.00
210402	Тээвэр, шатахуун	10,019,090.90	8,538,727.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,636,956.98	2,913,584.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	390,109.00	204,841.12
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,953,639.11	6,594,424.41
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	4,206,881.83	2,282,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,453,451.76</b>	<b>1,228,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,042,000.00	1,228,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,136,072.00</b>	<b>16,041,244.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,711,000.00	5,946,000.00
210604	Урсгал засвар	14,425,072.00	10,095,244.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,563,329.09</b>	<b>2,350,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,964,000.00	1,384,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,946,069.09	966,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>52,043,376.82</b>	<b>37,615,609.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,189,493.27	9,838,679.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	611,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,595.00	167,508.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	183,400.00	10,461,135.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	137,963.00	115,159.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	8,029,400.00	7,847,360.27

210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	1,716,950.29	6,774,767.63
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>46,890,224.30</b>	<b>37,040,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,186,902.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,083,998.00	15,191,435.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,806,226.30	15,661,963.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>18,109,152.77</b>	<b>37,876,700.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	-3,449,053.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		-3,449,053.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		3,449,053.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>18,109,152.77</b>	<b>34,427,647.00</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>440,936,697.00</b>	<b>513,397,024.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>440,936,697.00</b>	<b>513,397,024.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	412,764,534.00	503,827,623.00
120009	Бусад орлого	24,096,453.00	4,606,000.00
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	3,637,710.00	4,963,401.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>436,530,931.72</b>	<b>435,592,263.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>433,828,637.72</b>	<b>435,592,263.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>157,677,550.66</b>	<b>246,906,928.00</b>
210101	Үндсэн цалин	115,032,336.00	153,917,328.00
210102	Нэмэгдэл	10,414,616.48	21,094,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,529,645.00	16,608,000.00
210104	Урамшуулал	8,925,384.18	31,006,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,775,569.00	24,280,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,571,316.02</b>	<b>30,700,375.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		20,987,088.88
210202	Тэтгэмжийн даатгал		1,975,255.42
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,469,069.28
210204	Ажилгүйдлийн даатгал		493,813.86
210205	Эрүүл мэндийн даатгал		4,775,147.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,419,476.08</b>	<b>22,856,288.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,403,917.16	1,962,700.00
210302	Түлш, халаалт	3,750,558.92	3,832,948.00
210304	Байрны түрээс	12,300,000.00	17,060,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>39,679,032.81</b>	<b>29,136,020.52</b>
210401	Бичиг хэрэг	6,785,280.76	10,775,194.00
210402	Тээвэр, шатахуун	11,383,040.00	9,337,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,892,446.32	1,602,359.50
210404	Ном, хэвлэл	942,520.90	75,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	336,650.00	360,000.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	2,096,181.83	2,282,200.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн/ТӨҮГ/	12,458,450.00	4,702,967.02
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,312,000.00</b>	<b>1,228,500.00</b>



210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,312,000.00	1,228,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,136,072.00</b>	<b>16,041,244.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		230,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,711,000.00	5,946,000.00
210604	Урсгал засвар	14,425,072.00	9,865,244.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,707,420.00</b>	<b>3,591,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,964,000.00	3,231,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,090,160.00	360,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>115,799,272.15</b>	<b>69,261,346.11</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,004,385.00	3,405,620.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	619,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,595.00	167,508.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр		48,828.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	137,963.00	115,159.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	52,633,496.64	55,213,770.84
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	26,948,152.51	7,847,360.27
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,526,498.00</b>	<b>15,870,162.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,083,998.00	15,870,162.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>4,405,765.28</b>	<b>77,804,760.37</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>600,693.07</b>	<b>23,724,761.78</b>
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт		23,598,649.00
140007	Хүлээн авсан хүүний орлого	600,693.07	126,112.78
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>21,174,700.00</b>	<b>26,050,456.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,174,700.00</b>	<b>26,050,456.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>21,174,700.00</b>	<b>26,050,456.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	20,424,700.00	25,150,456.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	750,000.00	900,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-20,574,006.93</b>	<b>-2,325,694.22</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-16,168,241.65</b>	<b>75,479,066.15</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>39,063,583.48</b>	<b>22,895,341.83</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>22,895,341.83</b>	<b>98,374,407.98</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	830,830,863.0	955,462.77	113,851,467.61	945,637,793.38

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			6,803,435.66	6,803,435.66
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>120,654,903.27</b>	<b>120,654,903.27</b>
C07	Тайлант үеийн үр дүн			18,109,152.60	18,109,152.60
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>830,830,863.0</b>	<b>955,462.77</b>	<b>138,764,055.87</b>	<b>970,550,381.64</b>
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>830,830,863.0</b>	<b>955,462.77</b>	<b>138,764,055.87</b>	970,550,381.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,449,501.64	1,449,501.64
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>140,213,557.51</b>	140,213,557.51
D08	Тайлант үеийн үр дүн			34,427,647.00	34,427,647.00
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>830,830,863.0</b>	<b>955,462.77</b>	<b>174,641,204.51</b>	<b>1,006,427,530.28</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>394,508,838.4</b>	<b>511,624,790.0</b>	<b>435,592,263.4</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>197,226,872.0</b>	<b>280,000,000.0</b>	<b>246,906,928.0</b>
210101	Үндсэн цалин	124,807,905.0	175,800,000.0	153,917,328.0
210102	Нэмэгдэл	15,147,200.0	21,948,000.0	21,094,700.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,465,645.0	18,072,000.0	16,608,000.0
210104	Урамшуулал	30,732,877.0	38,260,000.0	31,006,200.0
210105	Гэрээт ажлын хөлс	12,073,245.0	25,920,000.0	24,280,700.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,207,559.4</b>	<b>35,000,000.0</b>	<b>30,700,375.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,318,784.6	23,800,000.0	20,987,088.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,577,815.0	2,240,000.0	1,975,255.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,971,968.7	2,800,000.0	2,469,069.3
210204	Ажилгүйдлийн даатгал	394,453.7	560,000.0	493,813.9
210205	Эрүүл мэндийн даатгал	3,944,537.4	5,600,000.0	4,775,147.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,419,475.0</b>	<b>22,532,560.0</b>	<b>22,879,140.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,403,917.0	1,193,800.0	1,844,000.0
210302	Түлш, халаалт	3,750,558.0	2,750,750.0	2,128,800.0
210303	Цэвэр, бохир ус		1,532,170.0	1,850,500.0
210304	Байрны түрээс	13,265,000.0	17,055,840.0	17,055,840.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,727,898.0</b>	<b>29,817,736.0</b>	<b>28,074,998.4</b>
210401	Бичиг хэрэг	6,785,280.8	9,373,600.0	9,373,600.0
210402	Тээвэр, шатахуун	9,060,000.0	7,517,640.0	9,337,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,892,446.3	3,814,000.0	3,814,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	336,650.0	396,000.0	396,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,279,456.0	2,600,996.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,711,000.0	5,437,040.0	2,552,802.4
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,312,000.0</b>	<b>4,684,000.0</b>	<b>5,397,500.0</b>

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,312,000.0	4,684,000.0	5,397,500.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,715,072.0</b>	<b>24,074,744.0</b>	<b>18,744,244.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,510,000.0	8,609,500.0	3,279,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	780,000.0	5,600,000.0	5,600,000.0
210604	Урсгал засвар	14,425,072.0	9,865,244.0	9,865,244.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,617,260.0</b>	<b>8,970,000.0</b>	<b>3,906,400.0</b>
210702	Дотоод албан томилолт	2,964,000.0	8,970,000.0	3,231,400.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			675,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,863,260.0</b>	<b>40,815,750.0</b>	<b>27,002,060.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,004,385.0	21,686,000.0	7,790,400.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.0	1,800,000.0	1,800,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.0	320,000.0	340,550.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,595.0	143,750.0	143,750.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,000.0	66,000.0	44,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,967,000.0	16,800,000.0	16,800,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж, татвар			83,360.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,542,448.0</b>	<b>34,510,000.0</b>	<b>24,430,162.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,458,450.0	11,560,000.0	8,560,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,083,998.0	22,950,000.0	15,870,162.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,702,294.0</b>	<b>1,500,000.0</b>	<b>1,500,000.0</b>
213208	Ахмадын сан	290,000.0	1,500,000.0	1,500,000.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,174,700.0</b>	<b>29,720,000.0</b>	<b>26,050,456.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>21,174,700.0</b>	<b>29,720,000.0</b>	<b>26,050,456.0</b>
223001	Бусад хөрөнгө	21,174,700.0	29,720,000.0	26,050,456.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>437,298,534.0</b>	<b>512,680,600.0</b>	<b>508,433,623.0</b>
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	412,764,534.0	512,680,600.0	503,827,623.0
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,534,000.0		4,606,000.0
620001	Удирдах ажилтан		1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан		15.0	14.0
620003	Үйлчлэх ажилтан		1.0	1.0
620004	Гэрээт ажилтан		4.0	3.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус газрын захирал Ц.Баяржаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Энхжин нар Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 150 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн алба нь “Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэвшилтэт технологид суурилсан, чанартай бүтээн байгуулалтын үр өгөөжийг дээшлүүлж, Эрдэнэт хотоо хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Барилгын стандарт, норм нормативын баримт бичгийн заалтыг хэрэгжүүлэх
- Орхон аймгийн нутаг дэвсгэрт бүх барилга, байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах, хяналт тавих, иргэдийн эрүүл аюулгүй, ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх
- Аймгийн хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дахин хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хот төлөвлөлт, хот байгуулалт, барилгын материалын үйлдвэрлэлтийн төрийн бодлогыг аймагт хэрэгжүүлэх.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын

хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

Тайлант хугацаанд тус байгууллагын дарга өөрчлөгдсөн байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн алба нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны дотоод хяналтын комисс нь 2020 онд Санхүү эдийн засаг, Үндсэн хөрөнгө эргэлтийн хөрөнгө, Хүний нөөц, Хөрөнгө оруулалтын ажил, Зураг төсөв гэсэн 5 үйл ажиллагааны чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчилтэй асуудлууд дээр зохих арга хэмжээг авч ажилласан байна.

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 169,924.08 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,699.24 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 462,663.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,626.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### **3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,253.36 мянган төгрөгөөр буюу 4.24 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,895.34	98,374.41	75,479.07
Авлага	25,747.78	20.36	(25,727.42)
Урьдчилгаа	14,877.96	1,200.00	(13,677.96)
Бараа материал	9,094.00	7,334.24	(1,759.76)
Үндсэн хөрөнгө	899,633.18	906,572.62	6,939.44
<b>Нийт хөрөнгө</b>	<b>972,248.27</b>	<b>1,013,501.63</b>	<b>41,253.36</b>
Өр төлбөр	1,697.88	7,074.10	5,376.22
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	970,550.38	1,006,427.53	35,877.15
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>972,248.27</b>	<b>1,013,501.63</b>	<b>41,253.36</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 98,374.11 мянган төгрөг болж 75,479.07 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Капитрон болон Төрийн банкин дах харилцах дансны үлдэгдлээр баталгаажиг байна.

Авлага дансны үлдэгдэл 20.36 мянган төгрөг болж 25,727.42 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ажилчдаас суутгасан ХХОАТ-ыг илүү шилжүүлснээс шалтгаалан тайлант хугацааны эцэст татварын авлагатай гарсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,200.0 мянган төгрөг байгаа нь “Номуунзолбоо” ХХК-д интернэтийн төлбөрийг урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой ба тайлант оны эцэст тус байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 7,334.24 мянган төгрөг болж 1,759.76 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 19,483.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 21,242.9 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 906,572.62 мянган төгрөг болж 6,939.44 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 26,050.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, Орхон аймгийн засаг даргын А804 тоот захирамжаар 15,860.0 мянган төгрөгийн балансын үнийн дүнтэй, 4,097.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй автомашиныг бүртгэлээс хасаж, 10,000.0 мянган төгрөгөөр шинэ автомашиныг бүртгэн авч, 24,800.4 мянган төгрөгийн балансын үнийн дүнтэй, 23,114.18 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг акталж, устгасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,074.10 мянган төгрөг болж 5,376.22 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ААНОАТ-ын өр 6,772.6 мянган төгрөг, НӨАТ-ын өр 301.4 мянган төгрөгийг дутуу шилжүүлснээс шалтгаалан, тайлант хугацааны эцэст татварын өртэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,006,427.53 мянган төгрөг болж 35,877.15 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой.

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 36,614.61 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн нь үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.



	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Хүүгийн орлого	600.69	126.11	(474.58)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	425,448.10	462,537.29	37,089.19
<b>Нийт дүн</b>	<b>426,048.80</b>	<b>462,663.41</b>	<b>36,614.61</b>

Нийт зардал өмнөх оноос 19,549.36 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь ажиллах хүчний орон тоо нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн, ковидын хөл хорионоос шалтгаалан томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж буурсан байна.

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	197,226.87	246,906.93	49,680.06
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,207.56	30,700.38	5,492.82
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,180.17	22,145.16	2,965.00
Хангамж, бараа материалын зардал	30,536.30	30,758.19	221.89
Нормативт зардал	3,453.45	1,228.50	(2,224.95)
Эд хогшил, урсгал засварын зардал	20,136.07	16,041.24	(4,094.83)
Томилолт, зочны зардал	10,563.33	2,350.40	(8,212.93)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,043.38	37,615.61	(14,427.77)
Бараа үйлчилгээний бусад зардал	46,890.22	37,040.30	(9,849.92)
<b>Нийт дүн</b>	<b>405,237.35</b>	<b>424,786.71</b>	<b>19,549.36</b>

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн алба нь төлөөлөн удирдах зөвлөлөөр 512,680.6 мянган төгрөгийн орлого, 511,624.8 мянган төгрөгийн зардлыг батлуулсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 435,592.26 мянган төгрөг буюу 85.2 хувьтай байгаа нь ковидтой холбоотой хөл хорионы үеэр ажилчдад зориулан сургалт зохион байгуулах ажил хойшлогдсон, томилолтын зардал багассан, мөн 2 ажилтны орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус байгууллага нь нэмэлт санхүүжилт төвлөрүүлээгүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл байсныг залруулж нөхөж мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж авсан ба биелэлтийг 2020 оны 06-р сарын 19-ны өдрийн 295 тоотой хариу тайлбар ирүүлэн ажилласан байна. Үүнээс анхан шатны баримтын иж бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг гаргахдаа борлуулалт, худалдан авалтын бүртгэлийг гарган, хөл дүнг тулгаж, тайлагнаж байх гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүй 2020 онд дахин алдаа зөрчил гаргасан байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Акт	1	57.8	1	57.8		
Албан шаардлага	1	230.0	1	230.0		
Зөвлөмж	3	3,684.2	1	0	2	3,684.2
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>3,972.0</b>	<b>3</b>	<b>287.8</b>	<b>2</b>	<b>3,684.2</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,211.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 800.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 310.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 101.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдэгээр баталгаажуулахгүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна. Тээврийн зардал 100.0 мянган төгрөг анхан шатны баримтгүй хувь хүний дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. 210.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг тухай бүрт нь авч хэрэглэсэн боловч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Зураг төслийн ажлын хөлс 800.0 мянган төгрөгийн орлогод НӨАТ ногдуулж тайлагнаагүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7.1.1-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ  
ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2021 оны санхүүгийн тайлангаар нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг зөв тайлагнаж буй эсэх, шатахууны орлогыг бүртгэж буй эсэх, анхан шатны баримтын иж бүрдэл хангалттай хийгдэж буй эсэх дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

**4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***Балансын данстай холбоотой асуудал***

1. Илрүүлэлт: 2 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг 48.4 мянган төгрөгөөр дутуу суутгаж олгосон ба байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 52.6 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна.
2. Эрсдэл: Цалингийн хүснэгт, нийгмийн даатгалын тайлан зөрөх.
3. Өгсөн зөвлөмж: "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтын дагуу шимтгэлийг зөв тооцож, тайлагнах.

Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 219 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

**Шилэн данстай холбоотой асуудал**

1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл байсан ба өмнөх оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг нөхөж мэдээлсэн байна.
2. Эрсдэл: Шилэн дансны мэдээллийн ил тод байдал алдагдах
3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Зөсгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2-т "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ" гэсэн заалтуудыг дагаж мөрдөж, мэдээллийг цаг хугацаандаа, үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших.
4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн Хот байгуулалт Барилга захиалагчийн албаны 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 219 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

Бэлтгэсэн:	Аудитор		Б.Пүрэвсүрэн	Огноо
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Б.Эрдэнэ	Огноо
Хоёр дахь шатанд хянасан:	Дарга, тэргүүлэх аудитор		Ц.Нармандах	Огноо

